



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/02

Модот

**Дотоод хяналтын баг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн "Дотоод хяналтын баг"-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Багийн ахлагч: Их эмч (Д.Болор-Эрдэнэ)

Гишүүд: Эх баригч бага эмч (Н.Эрдэнэтуяа)
Ахлах сувилагч (Ц.Хулан)

2. Дотоод хяналтын шалгалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.
3. Багын ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж, улирал бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн Эрхлэгчийн 2025 оны 01 дугаар сарын 23 -ны өдрийн А/05 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ИХ ЭМЧ  Ц.СЭВЖИД



Эрүүл мэндийн даргын
2026 оны 01 дугаар сарын 30-ны
өдрийн А/02 тоот тушаалын
хавсралт

ЦЭНХЭРМАНДАЛ ЭМТ-ИЙН ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

2317245267
ХТ10346 15 9075127

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. Энэхүү журам нь өөрийн ЭМТ-ийн хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах баримт бичиг мөн.
- 1.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хуулийн хүрээнд ил тод, бодитой, шударга зарчим баримтлана.
- 1.3. Дотоод хяналтын шалгалт нь ЭМТ-ийн үйл ажиллагааг бүрэн хамарсан байна.
- 1.4. ЭМТ-ийн бүх ажилагсад энэхүү дотоод хяналт шалгалтын журмыг дагаж мөрдөнө.
- 1.5. Дотоод хяналт шалгалтын журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Хоёр. Зорилго:

- 2.1. Дотоод хяналт шалгалтын журмын зорилго нь ЭМАШТУ болон НЭМТУ-г иргэдэд чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх, ажлын байрны аюулгүй байдал, үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, дахин гаргахгүй байх, ажлын бүтээмж чанарыг дээшлүүлэхэд оршино.

Гурав. Хамрах хүрээ:

- 3.1 Цэнхэрмандал сумын эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдана.

Дөрөв. Дотоод үйл ажиллагаа

- 4.1. Эмнэлэгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, мэргэжлийн алдаатай үйлдлийг хянан шалгаж, зохих ёсны арга хэмжээ авч ажиллана.
- 4.2. Анхан шатны маягтын хөтлөлт, стандарт, дүрэм журам, заавар тушаалын хэрэгжилтэнд дотоод хяналт хийж үр дүнг тооцоно.
- 4.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үйл ажиллгаанд дотоод хяналт тавьж ажиллана.
- 4.4. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, болзошгүй халдварын бэлэн байдал зэрэгт хяналт шалгалт хийж, зохих заавар зөвөлгөө өгнө.
- 4.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хяналт хийж ажиллана.
- 4.6. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, архив бичиг хэрэг, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 4.7. ЭМТ-ийн гадаад, дотоод тохижолтонд хяналт тавих, ногоон байгууламж байгуулах арга хэмжээ авч ажиллана.

Тав. Дотоод хяналт шалгалтын ажилтны эрх, үүрэг

- 5.1. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь байгууллагын удирдлагад захирагдана.
- 5.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь ЭМАШТУ-г чанартай үзүүлэх мэргэжил боловсрол эзэмшсэн ажлын дадлага туршлагатай байна.
- 5.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь удирдамж төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, хагас жил бүр үр дүнг тайлагнана.
- 5.4. Илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг тодорхойлон зөрчлийг арилгуулах, дахин зөрчил гаргуулахгүй арга хэмжээ авч ажиллана.

5.5. Хяналт шалгалтын явцын дүн, авсан арга хэмжээг улиралд 1 удаа удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан шаардлагатай бол хамт олонд мэдээлнэ.

5.6. Шаардлагатай бол зөрчил, дутагдал гаргасан ажилтанд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлнэ.

5.7. Хууль, эрх зүйн актуудыг өөрийн байгууллагад хэрэгжүүлэх, сурталчлах талаар сургалт зохион байгуулан ажиллана.

5.8. Өөрсдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвөлгөө авч өөрийн ажилд нэвтрүүлэн ажиллана.

5.9. Шийдвэрлэх боломжгүй зөрчлийг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах санал боловсруулан ажиллана.

5.10. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллана.

5.11. Дотоод хяналт шалгалтын тайланг улирал бүр мэргэжлийн хяналтын хэлтэст жилийн эцсийн тайланг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт явуулж байна.

Зургаа. Хариуцлага

6.1. Дотоод хяналт шалгалтаар зөрчил дутагдал гаргасан ажилтанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага ногдуулна.

6.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.